

Инно хими лаб ХХК



ИННО ХИМИ ЛАБ ХХК

МЭДЭЭЛЛИЙН НЭР:

**МИКРО ХУВАНЦАРЫН ИЛРҮҮЛЭЛТЭЭР
2025 ОНД ДЭЛХИЙД ТЭРГҮҮЛЭГЧ
ИННОВАЦИЙН 10 КОМПАНИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИЙДЛҮҮД**

Албан бус орчуулга

Мэдээллийн эх сурвалж: [Top 10 Innovative Microplastic Detection Companies in 2025](#)

Микрохуванцарын илрүүлэлтээр 2025 онд дэлхийд тэргүүлэгч инновацийн 10 компани нь байгаль орчны шийдлүүдээр тэргүүлж байна.

Өмнөх үг

Микро хуванцарыг илрүүлэх нь байгаль орчин, эрүүл мэндэд үзүүлэх нөлөөгөөр дэлхий дахинд чухал ач холбогдолтой болж байна. Хуванцарын бохирдол улам бүр нэмэгдсээр байгаатай холбогдон далай, цэнгэг усны эх үүсвэр, хөрс, агаар тэр ч байтугай хүний биед 5 мм-ээс бага хэмжээтэй микропластик буюу жижиг хуванцар хэсгүүд олдсоор байна.

Хуванцарын хэт тархалтаас болж хоруу чанар үүсгэх, хортой химийн бодисыг шингээх, далайн амьдрал, хүнсний сүлжээнд үзүүлэх нөлөөллийн талаар асуудал үүсгэж байна. Судалгаагаар ундны ус, далайн гаралтай хоол хүнс, хоолны давс тэр ч байтугай эхэст микрохуванцар илэрч байгаа нь хуванцарыг илрүүлэх, бууруулах үр дүнтэй стратеги арга хэмжээг яаралтай авах шаардлагатай байгааг харуулж байна.

Байгаль орчны хяналтыг өөрчилсөн шилдэг 10 компани

Компаний нэр	Agilent Technologies 	Bruker 	Perkin Elmer Inc 	Eurofins Scientific 
Байгуулагдсан он	1999	1960	1937	1987
Компанийн төв	Santa Clara, CA, USA	Billerica, MA, USA	Shelton, CT, USA	Luxemburg
Орлого (млрд)	\$6.51	\$3.37	\$3.312	\$6.8

Компаний нэр	EMSL Analytical Inc 	Satoorink	Thermo Fisher Scientific 	Shimadzu Corporation 
Байгуулагдсан он	1981	2022	1956	1875
Компанийн төв	Cinnamonson NJ, USA	Bannewitz, Saxony	Waltham, MA, USA	Kyoto, Japan
Орлого (млрд)	\$194.5 сая	\$4.5	\$2.86	\$ 6.51

Компаний нэр	Danahar Corporation 	Intertek Group 
Байгуулагдсан он	1984	1885
Компанийн төв	Washington, District of Columbia, USA	Bannewitz, Saxony, Germany
Орлого (млрд)	\$23.9	\$4.23

Agilent Technologies Inc Мөрдөх хууль зрх зүйн ахууд

1999 онд үүсгэн байгуулагдсан, АНУ-ын Калифорни мужид төвтэй, Agilent Technologies нь байгалийн шинжлэх ухаан, эмнэл зүйн оношлогоо, хэрэглээний химийн зах зээлийн аналитик стандартын гол тоглогч юм. Тус компани нь янз бүрийн орчинд микропластик илрүүлэх шинэлэг технологийг санал болгодог.

Байгалийн шинжлэх ухаан, Хэрэглээний зах зээл, Оношлогоо болон Генийн судалгаа гэсэн гурван гол үндсэн зах зээлийн хүрээнд ажиллахын зэрэгцээ Agilent CrossLab- Agilent ийн хэсэг нь бодисын физик, биологийн шинж чанарыг тодорхойлох, тоон агууламж гаргах, шинжлэхэд зориулагдсан багаж хэрэгсэл, хэрэглээний материал, програм хангамжийг зах зээлд нийлүүлдэг. Ажилентын үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнүүдэд шингэний хроматографи (LC) систем, хийн хроматографи (GC) систем, масс спектрометрийн хэрэгсэл, лабораторийн мэдээллийн системүүд багтдаг бөгөөд эдгээр нь бүгд микропластик шинжилгээнд чухал үүрэгтэй.

Thermo Fisher Scientific Inc

Thermo Fisher Scientific нь микропластик шинжилгээнд зориулсан олон төрлийн аналитик хэрэгсэл, шийдлүүдийг санал болгодог шинжлэх ухааны бүтээгдэхүүн үйлчилгээгээр дэлхийн тэргүүлэгч юм. Тус компани нь савласан далайн гүний ус, үйлдвэрийн хаягдал урсгал зэрэг янз бүрийн дээжийн эх үүсвэрт микропластикийг тодорхойлох, тоо хэмжээг тогтооход тусалдаг. FTIR болон Раман спектроскопийн шийдлүүдийг санал болгодог. Термо Фишер нь микропластик илрүүлэх хамгийн сүүлийн үеийн судалгаа, шинжилгээний хэрэгслүүдийн талаар үйлчлүүлэгчдэд мэдлэг олгох, зөвлөгөө өгөх дэлхийн хэмжээний симпозиумуудыг зохион байгуулдаг.

Bruker Corporation

1960 онд байгуулагдсан, Массачусетс мужид төвтэй Bruker нь шинжлэх ухааны багаж хэрэгсэл, аналитик шийдлүүдийг зах зээлд нийлүүлдэг тэргүүлэгч компани юм. Тус компани нь BSI BioSpin, BSI CALID, BSI Nano зэрэг сегментүүдээр дамжуулан үйл ажиллагаагаа явуулдаг.

BSI CALID сегмент нь масс спектрометр ба ионы шилжилтийн спектрометр мөн аналитик болон процессын шинжилгээний багажууд зэрэг байгалийн шинжлэх ухааны салбарт мэргэшсэн компани юм. Bruker нь микропластикийг илрүүлэх шинжилгээнд хэт улаан туяаны болон Раман молекулын спектроскопи, түүнчлэн хими, биологи, радиологи, цөмийн болон тэсрэх аюулыг илрүүлэх зориулалттай цацрагийн болон цөмийн детекторуудыг ашигладаг шийдлүүдийг санал болгодог.

Shimadzu Corporation

Шимадзу нь 1875 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд Японы Киото хотод төвтэй, нарийвчлал өндөртэй багаж үйлдвэрлэлээрээ алдартай компани юм. Тус компани нь бизнесийн таван чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд аналитик болон хэмжих хэрэгслийн салбар нь микропластик илрүүлэхэд зайлшгүй шаардлагатай хийн

болон шингэний хроматограф-масс спектрометр, хийн хроматограф-масс спектрометр, шингэн хроматограф-масс спектрометр зэрэг өргөн хүрээний багажуудыг үйлдвэрлэдэг.

Эдгээр багажууд нь керамик, металл ба уул уурхай, клиник болон шүүх эмнэлэг, электроник, хоол хүнс, ундаа, механик болон автомашины үйлдвэрлэл, нефтийн хими, химийн бодис, эм зүй, амьдралын шинжлэх ухаан зэрэг төрөл бүрийн салбарт үйлчилдэг. Shimadzu нь Японд 8, хилийн чанадад 9 үйлдвэрлэлийн 17 газартай дэлхийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг.

Бусад компаниудын товч танилцуулгыг англи эх сурвалжаас харна уу.

Инно Хими Лаб ХХК – ийн танилцуулга:


Үйлчилгээний нэр төрөл:

- Хүнс, хүрээлэн буй орчны шинжилгээний лабораторийн шинжилгээ
- Химийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, бодис, урвалжийн худалдаа
- Химийн тоног төхөөрөмжийн суурилуулалт, засвар үйлчилгээ
- Химич, химийн мэргэжилтний сургалт, зөвлөгөө

Бүтээгдэхүүний нэр төрөл:

- Тоног төхөөрөмж
- Багаж хэрэгсэл
- Урвалж, уусмал
- Стандарт бодис, оношлуур
- Химийн бодис
- Шил сав, дагалдах хэрэгсэл

Хэрэглэгчидийнхээ цаг завьг хэмнэх, тасралтгүй ажиллагааг дэмжих үүднээс www.innochem.mn онлайн худалдааны сайтыг нэвтрүүлээд байна.



Инно лаборатори

- Химийн лабораторийн мэргэжилтнүүдэд өндөр хүчин чадал бүхий тоног төхөөрөмжтэй ажиллах орчин бүрдүүлэх, чадамжийг сайжруулах
- Хүнсний болон хүрээлэн буй орчны аюулгүй байдлыг хангахад лабораторийн шинжилгээг олон улсын стандартын дагуу нэвтрүүлж хувь нэмрээ оруулах

Шинжилгээний хүрээ:

- Пестицидийн үлдэгдлийн шинжилгээ
- Усанд болон тосонд уусдаг витаминь шинжилгээ
- Хүрээлэн буй орчны бохирдлын шинжилгээ